

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/001/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Говьсүмбэр  
аймаг

2026 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543179, Цахим хаяг:  
[sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Наранбаяр

Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)

Аудитор: С.Батцэцэг

Цахим хаяг: [battsetsegsa@audit.gov.mn](mailto:battsetsegsa@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу..

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2026.03.16 № 52  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН "ТОХИЖИЛТ  
СҮМБЭР" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Ц.ЭНХЖАРГАЛ ТАНАА

#### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ -ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4226050234



**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>151,893,678.33</b>	<b>544,287,722.20</b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>14,463,870.29</b>	<b>298,431,281.67</b>
Банкинд байгаа бэлэн мөнгө	14,463,870.29	298,431,281.67
Төгрөг	14,463,870.29	298,431,281.67
Арилжааны банк дахь харилцах	14,463,870.29	298,431,281.67
<b>АВЛАГА</b>	<b>34,528,880.04</b>	<b>29,917,948.53</b>
Бусад авлага	34,528,880.04	29,917,948.53
Байгууллагаас авах авлага	34,528,880.04	3,657,000.00
Хувь хүмүүсээс авах авлага		26,260,948.53
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>102,900,928.00</b>	<b>215,938,492.00</b>
Хангамжийн материал	102,900,928.00	215,938,492.00
Аж ахуйн материал	102,900,928.00	215,938,492.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,583,067,843.84</b>	<b>12,971,128,779.98</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>12,583,067,843.84</b>	<b>12,971,128,779.98</b>
Биет хөрөнгө	12,363,572,000.29	12,419,788,779.98
Барилга, байгууламж, орон сууц	2,690,024,020.80	3,139,212,376.80
Хуримтлагдсан элэгдэл	-329,723,336.03	-602,018,223.87
Авто-тээврийн хэрэгсэл	1,079,162,000.00	967,762,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-437,304,966.09	-380,568,832.99
Машин тоног төхөөрөмж(компьютер)	30,680,800.00	33,680,600.00
Хуримтлагдсан элэгдэл	-12,615,548.23	-14,163,426.81
Тавилга, аж ахуйн эд хогшил	11,082,328.57	11,007,328.57
Хуримтлагдсан элэгдэл	-5,987,286.47	-4,264,840.28
Зам, гүүрийн байгууламж	7,540,060,615.00	8,526,406,601.00
Хуримтлагдсан элэгдэл	-2,633,284,185.03	-3,052,670,654.87
Бусад үндсэн хөрөнгө	7,880,891,893.87	7,763,541,320.27
Хуримтлагдсан элэгдэл	-3,912,073,907.10	-3,968,135,467.84
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>219,495,843.56</b>	<b>551,340,000.00</b>
Програм хангамж	20,118,374.00	7,983,374.00
Хуримтлагдсан элэгдэл	-18,122,530.44	-7,983,374.00
Бусад биет бус хөрөнгө	317,890,000.00	551,340,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-100,390,000.00	
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>12,734,961,522.18</b>	<b>13,515,416,502.18</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,464,754,413.13</b>	<b>11,885,456,231.03</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>706,850.00</b>	<b>0.00</b>

<b>Өглөг</b>	<b>706,850.00</b>	<b>0.00</b>
<b>Бусад өглөг</b>	<b>706,850.00</b>	<b>0.00</b>
Байгууллагад төлөх өглөг	706,850.00	0.00
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,464,047,563.13</b>	<b>11,885,456,231.03</b>
<b>Урт хугацаат зээл</b>	<b>11,464,047,563.13</b>	<b>11,885,456,231.03</b>
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	11,464,047,563.13	11,885,456,231.03
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,756,541,691.73</b>	<b>1,629,960,271.15</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,756,541,691.73</b>	<b>1,202,727,269.45</b>
Засгийн газрын оруулсан капитал	2,202,002,208.14	2,502,002,208.14
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,202,002,208.14	2,502,002,208.14
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-938,600,429.97</b>	<b>-1,299,274,938.69</b>
Өмнөх үеийн үр дүн	-447,265,847.34	-897,325,099.09
Тайлант үеийн үр дүн	-491,334,582.63	-401,949,839.60
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,805,330.88	427,233,001.70
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>12,734,961,522.18</b>	<b>13,515,416,502.18</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,655,316,547.78</b>	<b>2,216,173,261.72</b>
Борлуулалтын орлого	237,930,214.00	267,500,290.65
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,417,386,333.78</b>	<b>1,948,672,971.07</b>
Нийтлэг татварын бус орлого	1,417,386,333.78	1,948,672,971.07
Бусад орлого	1,179,156,570.00	1,946,250,134.00
Хүүгийн орлого	238,229,763.78	2,422,837.07
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,836,520,003.05</b>	<b>2,618,123,101.32</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,836,520,003.05</b>	<b>2,618,123,101.32</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,836,520,003.05</b>	<b>2,618,123,101.32</b>
Борлуулалт, маркетингийн зардал		1,054,096,865.13
Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	1,836,520,003.05	1,503,853,192.19
Бусад зардал		60,173,044.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-419,133,669.27</b>	<b>-401,949,839.60</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>72,200,913.36</b>	<b>0.00</b>
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	72,200,913.36	0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-491,334,582.63</b>	<b>-401,949,839.60</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,415,222,378.74</b>	<b>2,222,456,548.23</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,415,222,378.74</b>	<b>2,222,456,548.23</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,415,222,378.74</b>	<b>2,222,456,548.23</b>
Татаас, санхүүжилтын орлого	1,117,928,828.00	1,917,471,900.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	246,790,762.96	268,781,342.16
Бусад орлого	50,502,787.78	36,203,306.07
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,409,555,347.11</b>	<b>1,929,083,336.85</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,409,555,347.11</b>	<b>1,929,083,336.85</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>498,910,255.00</b>	<b>776,136,245.00</b>
Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	498,910,255.00	776,136,245.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>96,297,143.49</b>	<b>182,315,912.55</b>
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	96,297,143.49	182,315,912.55
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>109,070,615.28</b>	<b>118,799,237.21</b>
Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	109,070,615.28	118,799,237.21
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>265,571,486.20</b>	<b>361,754,627.00</b>
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		39,553,496.00
Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	265,571,486.20	322,201,131.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>323,339,270.94</b>	<b>490,077,315.09</b>
Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	44,224,902.00	76,755,391.00
Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	279,114,368.94	413,321,924.09
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>5,667,031.63</b>	<b>293,373,211.38</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>9,450,000.00</b>	<b>9,405,800.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,450,000.00</b>	<b>9,405,800.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>9,450,000.00</b>	<b>9,405,800.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,450,000.00	9,405,800.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-9,450,000.00</b>	<b>-9,405,800.00</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-3,782,968.37</b>	<b>283,967,411.38</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-3,782,968.37</b>	<b>283,967,411.38</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,246,838.66	14,463,870.29
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,463,870.29	298,431,281.67

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	(903,480,429.97)	1,305,327,109.05
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	(903,480,429.97)	1,305,327,109.05
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	(938,600,429.97)	1,270,207,109.05
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			41,275,330.88	41,275,330.88
Залруулсан үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	(897,325,099.09)	1,311,482,439.93
Өмчид гарсан өөрчлөлт	300,000,000.00	(6,805,330.88)		293,194,669.12
Тайлант үеийн үр дүн	-	427,233,001.70	(401,949,839.60)	25,283,162.10
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,502,002,208.14	427,233,001.70	(1,299,274,938.69)	1,629,960,271.15

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**  
Байхгүй

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

### **Завсрын аудитаар илэрсэн алдаа, зөрчил**

2025 оны 3-р улирлын байдлаар хийсэн завсрын аудитаар өгсөн 330,842.4 мянган төгрөгийн 2 алдаа, 4 зөрчил илэрсэн. Завсрын аудитаар илэрсэн 2 алдааг жилийн эцсийн тайланд залруулж ирүүлсэн байна.

#### **5.3.1 Дотоод хяналттай холбоотой**

**5.3.1. Илрүүлэлт** Санхүүгийн байдлын тайлан дахь мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 406.0 сая төгрөгийг харилцагч банкуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 17 дугаар зүйлийн 17.1.2-т “холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

**5.3.2. Илрүүлэлт** Төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хүлээн авч хойшлогдсон өр төлбөрөөр бүртгэсэн хөрөнгөд ногдох элэгдлийн зардлыг тооцож хойшлогдсон татварын өр төлбөрийг бууруулах бичилт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 17 дугаар зүйлийн 17.1.2-т “холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дансны бичилтийг тухай бүр үнэн зөв хөтлөх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

**5.3.3. Илрүүлэлт** Жолоочийн тооцооны хуудсанд 106.0 мянган төгрөгийн тооцоо бичигдээгүй, 34.3 мянган төгрөгийн тооцоог давхардуулж бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 17 дугаар зүйлийн 17.1.2-т “холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, заалтуудыг зөрчсөн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шатахууны тайланг тухай бүр хянах, анхан шатны баримтыг бүрдлийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

## **Залруулсан алдаа:**

Аудитаар нийт 363,388.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад алдааг бүрэн залруулсан.

### *Залруулаагүй алдаа:* Байхгүй

Аудитаар нийт 140.3 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрч зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Аудитаар нийт 140.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа буюу зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Өөрчлөлтгүй

## **1.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

## **3.2 Албан шаардлага**

**3.2.1. Илрүүлэлт:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Шилэн дансны цахим хуудсыг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

### 1. Шилэн дансны хуулийн хэрэгжилт

**1.1. Илрүүлэлт:** Тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим 71,223.2 мянган төгрөгийн 7 тушаал, гэрээг мэдээллийг байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” 6 дугаар зүйлийн 6.4.8-нд “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11-т “зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар” гэсэн заалтуудтай зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.2.2. Илрүүлэлт:** 1.1. Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасныг зөрчиж 1,153.2 мянган төгрөгийн шатахууныг суудлын автомашинд зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

### **3.3 Зөвлөмж**

Дотоод хяналттай холбоотой асуудал

- 3.3.1 Санхүүгийн байдлын тайланд аюултай хог хаягдал түр хадгалах зориулалттай 300,000.0 мянган төгрөгийн газрыг эздийн өмчөөр бус хойшлогдсон өр төлбөрөөр бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- 3.3.2 Мөнгөн хөрөнгийн тодруулга тайлангийн эхний үлдэгдэлд мөнгөн хөрөнгийн дүнг сөрөг 29,548.9 мянган төгрөгөөр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.
- 3.3.3 Эзэмшилд бүртгэлтэй газарт 33,840.0 мянган төгрөгийн элэгдэл тооцсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, заалтуудыг зөрчсөн Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна. Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨҮГ	1	1			1			
3	Төсөл, хөтөлбөр								
4	ЗГТС								
5	ТТЗ								
6	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			